

ГАДААДАД ЭМЧЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ИРГЭДИЙН СУДАЛГАА**НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ:**

Гадаадад эмчлүүлэгчдийн тоо жил тутам нэмэгдэж байгаа нь нэг талаас гадаадад эмчлүүлэх эрмэлзэлтэй, санхүүгийн хараат бус иргэдийн тоо өссөн, нөгөө талаас манай улсын эмнэлгийн техник, технологийн хөгжил, оношилгоо, эмчилгээний чанар хангалтгүй байгаатай шууд хамааралтай байна.

Түүнчлэн янз бүрийн зуучлагч байгууллагууд ямар нэг хяналтгүйгээр, эх орондоо эмчлүүлэх боломжтой өвчнийг гадаадад эмчлүүлэхийг зөвлөдөг, илгээдэг байдлууд ч нөлөөлж байна.

ЭМХТ-өөс 2013 онд хийсэн Гадаадад эмчлүүлэгчдийн судалгаанд “Гадаадад эмчлүүлэх талаар эрх зүйн нэгдсэн зохицуулалт хангалтгүй байгаагаас баримтлах стратегийн шийдэл, хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагаа хангалтгүй байна” гэж дүгнээд¹.

Зөвлөмжид:

- Гадагшаа чиглэсэн тусламж үйлчилгээг өөрийн оронд үзүүлэх эсвэл зарим өртөг өндөртэй тусламж үйлчилгээг гадаад орноос авах эдийн засгийн тооцоолол, харьцуулалтын нарийвчилсан судалгаа хийх
- Монгол улсын иргэд хамгийн их эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байгаа орнуудтай иргэдийн мэдээллийг солилцох боломжийг судлах
- Монгол улсын иргэд ямар оношоор ихэвчлэн гадаад орныг зорьж буй талаар нарийвчилсан судалгаа хийх
- Монгол улсын иргэдийг гадаад орон руу оношилгоо, эмчилгээнд зуучлах үйл ажиллагаа эрхлэгчдэд эрх зүйн зохицуулалтыг бий болгох боломжийг судлан шийдвэрлэх² гэсэн байна.

Мөн Монгол улсын эрүүл мэндийн сайдын 2013 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 313 дугаар тушаалаар:

- Монгол улсын иргэн өөрийн оронд эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх “Өвчний жагсаалт”-ыг нэгдүгээр;
- “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”ийг хоёрдугаар;
- “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг гуравдугаар;
- “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах журам”-ыг дөрөвдүгээр;
- Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлтийн маягт”-ыг тавдугаар хавсралтаар баталсан нь эрх зүйн гол орчин болж байна.

Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар 33 өвчний жагсаалтыг баталсан ба энэ дагуу гарган, иргэдэд тодорхой хэмжээгээр буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлж байгаа боловч гадаадад эмчлүүлэх шаардлагатай ч, явж чадахгүй байгаа олон иргэд байна. Иймд гадаадад эмчлүүлэх шаардлагатай гэсэн эмнэлгийн дүгнэлт гарсан боловч, явж чадахгүй байгаа иргэдийн хэрэгцээг цахимаар болон утсан холбоогоор судлаж, иргэдийн оролцоо, бодит байдалд тулгуурлан эрүүл мэндийн салбараас оновчтой бодлогоор дэмжин, хамтарч ажиллах нь энэхүү судалгааны үндэслэл болж байна.

Судалгааны зорилго: Гадаадад оношлуулах, эмчлүүлэх шаардлагатай иргэдийн хэрэгцээг судлах

Судалгааны зорилт:

1. Гадаадад оношлуулах, эмчлүүлэх шаардлагатай иргэдийн хэрэгцээг судлах
2. Нотолгоонд үндэслэн гадаадад эмчлүүлэх шаардлагатай иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан шийдвэр гаргахад бодлогоор дэмжлэг үзүүлэх

Судалгааны үр дүн: Гадаадад оношлуулах, эмчлүүлэх шаардлагатай иргэдийн хэрэгцээг судалсан тайлан, зөвлөмж гарна.

¹Гадаадад эмчлүүлэгчдийн судалгааны дүгнэлт, Т.Өнөрцэцэг, Л.Ширнэн, 2013 он, ЭМХТ

² Гадаадад эмчлүүлэгчдийн судалгааны зөвлөмж, 2013 он, ЭМХТ

Судалгааны хамрах хүрээ: 2014 оны 03 дугаар сарын 10-аас 2014 оны 04 дүгээр сарын 16 хүртэл 30 хоногийн хугацаатайгаар гадаадад эмчлүүлэх шаардлагатай нь нотлогдсон, эмчийн дүгнэлт гаргуулсан боловч явж чадахгүй байгаа Монгол улсын иргэдийг хамруулахыг зорьсон. Гэхдээ судалгаа хийж байх хооронд дүгнэлт гаргуулаагүй боловч оролцохыг хүссэн иргэд олноор хандсан тул нээлттэйгээр хүссэн хүн бүрийг хамруулсан болно.

Аргачлал: Тоон судалгааны аргаар, тусгайлан боловсруулсан асуулгаар цахимаар болон утсан холбоог ашиглан нээлттэй судалгаа авсан. Гадаадад эмчлүүлэх шаардлагатай гэсэн эмнэлгийн дүгнэлт гаргуулсан иргэд тус судалгаанд хамрагдсан. Судалгааны үнэн бодит байдлыг хангахын тулд дүгнэлт гаргасан эмнэлэг, эмчээс түүврийн аргаар зарим нэг нотолгоо авсан болно.

Судалгааны ёс зүй ба зөвшөөрөл: Хувь хүн өөрийнхөө хүсэлтээр, асуулгын дагуу нээлттэйгээр судалгаанд хамрагдсан.

Судалгааны зааварчилга:

- 2014 оны 03 дугаар сарын 10-аас 04 дүгээр сарын 15-ыг дуустал хугацаанд, ажлын өдрөөр 09.00 -17.00 цагийн хооронд мэдээлэл цуглуулсан.
- Цахим болон утсаар авах судалгаанд гадаадад эмчлүүлэхээр эмнэлгийн дүгнэлт гаргуулсан боловч явж чадаагүй иргэд хамрагдсан.
- Утсаар судалгааг авахдаа харилцагчийн асуултад хариулан, харилцан ярилцаж, зарим тодруулгыг хийх зарчмаар ажилласан.

Судалгааны хүн хүчин: Судалгааны үр дүнгийн тайланг ЭМХТ-ийн захирал Ч.Бат-Эрдэнэ, ТССХ-ийн дарга Н.Нарангэрэл нар хянан тохинуулж, ахлах мэргэжилтэн Л.Ширнэн дүн шинжилгээ хийн үр дүнгийн тайланг бичлээ. Мэдээллийн нэгтгэл, боловсруулалтыг ТССХ-ийн мэргэжилтэн П.Эрхэмбаяр гүйцэтгэн, мэдээлэл цуглуулахад ТССХ-ийн мэргэжилтэн П.Эрхэмбаяр, Э.Ундармаа, Ц.Мөнх-Од, Д.Алтанцэцэг, ЯТЗХ-ийн мэргэжилтэн Б.Гантөмөр болон алсын дуудлага зохицуулагч бага эмч нар ажиллав.


Судалгааны бэрхшээл: Эмнэлгээс дүгнэлт гаргуулаагүй боловч, өөрсдийн хүсэлтээр гадаадад оношлуулах, эмчлүүлэх хүсэл эрмэлзэлтэй хүмүүс судалгаанд хамрагдсан тул ачааллыг ихэсгэх, мөн гадаадад эмчилгээнд явуулахаар бүртгэж байна гэсэн итгэл үнэмшлээр хандан, хэзээ явуулахыг дахин утасдаж лавлах, ямар арга хэмжээ авах талаар тодруулга хийх зэрэг бэрхшээл учирч байв.

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Гадаадад эмчлүүлэх шаардлагатай иргэдийн ерөнхий мэдээлэл

Гадаадад эмчлүүлэх шаардлагатай иргэдийн судалгааг аргачлалын дагуу 2014 оны 03 дугаар сарын 10-аас 2014 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.chd.moh.mn цахим хаягаар болон 9313-1766, 9313-1767, 9313-7804, 9862-2495, 9864-8801 дугаар утсаар авлаа. Мөн судалгаа авч буй талаар TV-C1, TV-25MN зэрэг телевизын сувгуудаар мэдээлэл цацагдан олон нийтэд хүрсэн.


ДҮРСЛЭЛ 1. ГАДААДАД ЭМЧЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ИРГЭДИЙН ХАМРАГДАЛТ



Энэ дагуу 30 хоногийн хугацаанд цахим хаягаар 127, утсаар 295, нийт 422 иргэн судалгаанд өөрийн хүсэлтээр нээлттэй оролцсон ба дийлэнх нь (69.9%) утсаар судалгаанд хамрагдсан байна. Бид судалгаанд оролцогчдоос зарим асуулгыг нягтлах зорилгоор эргэн мэдээлэл, харилцах утасны дугаар зэргийг авсан болно.

Судалгаанд 0-15 насны 87, 16-29 насны 79, 30-39 насны 77, 40-49 насны 79, 50-59 насны 71, 60 ба түүнээс дээш насны 29 иргэн хамрагдсан байна. Хүйсээр авч үзвэл судалгаанд хамрагдсан иргэдийн 48.3% нь эрэгтэй, 51.4% нь эмэгтэйчүүд байна.

ДҮРСЛЭЛ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭД НАСНЫ БҮЛГЭЭР



Гадаадад эмчлүүлэх шаардлагатай иргэдийн цөөнгүй хувийг 0-15 насны хүүхдүүд эзэлж байгаа ба 16-39 насны залуучууд 36.9%-ийг, 40-49 насныхан 18.7%-ийг, 50 ба түүнээс дээш насныхан 23.8%-ийг эзэлсэн байна.

2.2. Гадаадад эмчлүүлэх шаардлага, хэрэгцээ

Бид гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэхээр эмнэлгийн дүгнэлт гаргуулсан иргэдээс судалгаа авахыг зорьсон болно. Гэсэн хэдий ч өөрсдийн хүсэлтээр гадаадад оношилгоо, эмчилгээ хийлгэх сонирхолтой иргэд цөөнгүй хандсан ба бид иргэдийн тэнцвэртэй оролцоог хангах үүднээс судалгаанд хамруулсан.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 313 дугаар тушаалаар гадаадад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдийн эмнэлгийн дүгнэлт гаргах журмыг баталсан.


Энэ дагуу лавлагаа төвийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын комиссын шийдвэр гардаг ба мөн гадаадад эмчилгээ хийлгээд ирсний дараа санхүүгийн дэмжлэг авах боломж нь бүрддэг байна.

Манай судалгаанд оролцсон иргэдийн 325 (77.0%) нь төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвөөр дүгнэлт гаргуулсан гэсэн байна. Харин 60 (14.2%) нь хувийн хэвшлийн эмнэлгээр, 23 (5.4%) нь дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, амаржих газраар, 14 (3.3%) нь дүгнэлт гаргуулаагүй боловч судалгаанд хамрагдсан байна.

Бид судалгааны аргачлалд заасны дагуу хамгийн олон дүгнэлт гаргуулсан гэж нэрлэсэн Улсын нэгдүгээр төв эмнэлэг (УНТЭ), Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ), Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-ийн асуудал хариуцсан мэргэжилтнээс мэдээлэл авлаа.

УНТЭ-ээр 2013 онд 50 хүн, 2014 онд 29 хүн, УГТЭ-ээс 2013 онд 173, 2014 онд 33, ХСҮТ-өөс 2013 онд 9, 2014 онд 5, ЭХЭМҮТ-өөс 2013 онд 4, 2014 онд 8, бүгд 311 иргэнд дүгнэлт гаргасан байна.

ДҮРСЛЭЛ 3. ГАДААДАД ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭХ ДҮГНЭЛТ ГАРГАСАН БАЙДАЛ, БАЙГУУЛЛАГААР



Гадаадад оношлуулах, эмчлүүлэх хэрэгцээг тодорхойлохдоо Эрүүл мэндийн сайдын 2011 оны 107, 2013 оны 313 дугаар тушаалын гадаадад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний

жагсаалтад орсон болон ЭМХТ-ийн Гадаадад эмчлүүлэгчдийн судалгааны тэргүүлэх байранд орсон онош, эмчилгээг сонгосон болно.

Мөн бусад гэсэн асуулгаар өвчний жагсаалтад ороогүй, гадаад оронд оношилгоо, эмчилгээ хийлгэх шаардлагатай хэрэгцээг цуглуулан, өвчний олон улсын ангиллын оношийн бүлгийн дагуу ангилан дүн шинжилгээ хийсэн. Судалгаанд хамрагдсан иргэдийн 54.9% нь асуулгад орсон оношилгоо, эмчилгээг нэрлэсэн бол 190 иргэн буюу 45.1% нь бусад өвчний улмаас гадаадад эмчлүүлэх шаардлагатай байгаагаа илэрхийлсэн ба тус бүрээр нь задлан авч үзсэн болно.

ДҮРСЛЭЛ 4. ГАДААД УЛСАД ОНОШЛУУЛАХ, ЭМЧЛҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ (Зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалтаар)



Гадаадад оношлуулах, эмчлүүлэх өвчний оношийг эхний 5 байраар авч үзвэл:

- Төрөл бүрийн хавдар 74 (17.5%)
- Зүрхний төрөлхийн болон олдмол гажиг 38 (9.0%)
- Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал 31(7.3%)
- Зүрхний титэм судасны бүтцийн нарийсал 27 (6.3%)
- Нугас ба нугасны ёзоорын дарагдлын мэс засал 23 (5.45%)
- Бусад шалтгаан 190 (45%) хүн тус тус оношилгоо, эмчилгээ хийлгэх шаардлагатай гэсэн байна.

Бусад шалтгааныг дурдсан 190 (45.0%) иргэний оношилгоо, эмчилгээг өвчний олон улсын ангиллын дагуу дүн шинжилгээ хийлээ.

ДҮРСЛЭЛ 5. ГАДААДАД ОНОШЛУУЛАХ, ЭМЧЛҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ-БУСАД ШАЛТГААН (ӨОУА-ын оношийн бүлгээр)



Гадаадад оношлуулах, эмчлүүлэх өвчний бусад шалтгааныг эхний 6 байраар авч үзвэл:

- Мэдрэлийн тогтолцооны 57 (30.0%)
- Зүрх судасны 24 (12.6%)
- Хоол боловсруулах тогтолцооны 21 (11.0%)
- Гэмтэл хордлого гадны шалтгаант тодорхой эмгэгийн 21 (11.0%)
- Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн 23 (12.1%)
- Шээс бэлгийн тогтолцооны 14 (7.4%) тохиолдол тус тус орж байна.

Эндээс дүгнэхэд гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний тэргүүлэх байранд төрөл бүрийн хавдар, зүрхний гажиг орж байгаа бол бусад шалтгаанд мэдрэлийн тогтолцоо, зүрх судасны өвчин хамгийн өндөр байна.

ХҮСНЭГТ 1. ГАДААД УЛСАД ЭМЧЛҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ- НАСНЫ БҮЛГЭЭР

(тоогоор)

д/д	Оношилгоо, эмчилгээний нэршлээр	0-15	16-29	30-39	40-49	50 +	Бүгд
1	Гамма туяа эмчилгээ	1	5	3	1	1	11
2	Төрөл бүрийн хавдарууд	11	15	7	16	25	74
3	Нугас ба нугасны ёзоор мэс засал	6	4	2	2	9	23
4	Зүрхний титэм судасны нарийсал	1	2	3	6	15	27
5	Ясны чөмөг суулгах мэс засал	3		3	2		8
6	Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал	2	6	5	13	5	31
7	Нүдний, торон бүрхүүлийн мэс засал	1	1	1	2	2	7
8	Зүрхний төрөлхийн болон олдмол гажиг	18	5	2	8	4	37
9	Үр шилжүүлэн суулгах		1	9	1		11
10	Үргүйдэл			1	1		2
11	Мэдрэлийн тогтолцооны өвчин	21	12	6	9	9	57
12	Зүрх судасны		6	6	3	9	24
13	Гэмтэл хордлого гадны шалтгаант эмгэг	2	3	6	4	6	21
14	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1	4	7	7	2	21
15	Яс булчингийн тогтолцооны өвчин	3	4	5	1	2	15
16	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	3	2	5	2	2	14
17	Амьсгалын тогтолцооны өвчин		1	2		3	6
18	Нүд ба түүний дайврын өвчин	1			2	3	6
19	Дотоод шүүрэл, бодисын солилцооны	2	2	2			6
20	Төрөлхийн гажиг ба гаж хөгжил	3	2				5
21	Халдварт ба шимэгчит зарим өвчин		2		2	1	5
22	Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	3					3
23	Арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин	2				1	3
24	Сэтгэцийн ба зан төрхийн гажиг			1		1	2
25	Онош тодорхойгүй	1		2			3
26	Бүгд	85	77	78	82	100	422

Гадаадад эмчлүүлэх шаардлагатай гэсэн иргэдийн хэрэгцээг насны бүлгээр ангилан авч үзвэл:

- Бүх насанд төрөл бүрийн хавдар,
- 0-15 насанд хавдар, мэдрэлийн тогтолцооны өвчин, зүрхний гажиг,
- 16-29 насанд төрөл бүрийн хавдар, мэдрэлийн тогтолцооны өвчин,
- 30-39 насанд хавдар, үр шилжүүлэн суулгах,
- 40-49 насанд эрхтэн шилжүүлэн суулгах, хавдар,
- 50 ба түүнээс дээш насанд хавдар, зүрхний титэм судасны нарийсал, нугас, нурууны ёзоорын дарагдал өвчний оношилгоо, эмчилгээ илүү хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

Эдгээрээс төрөл бүрийн хавдар, эрхтэн шилжүүлэн суулгах, зүрхний титэм судасны бүтцийн нарийсал өвчин гадаадад эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай өвчний жагсаалтад орсон байна.

**ХҮСНЭГТ 2. ГАДААДАД ОНОШЛУУЛАХ, ЭМЧЛҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ,
ӨОУА-ЫН ОНОШИЙН БҮЛГЭЭР**

Өвчний нэршил	Тоо	Өвчний нэршил	Тоо
<i>Бусад шалтгаан нэрлэсэн 190 иргэдийн хэрэгцээг харуулав.</i>			
I.Мэдрэлийн тогтолцооны	57	VII. Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны	5
• Булчингийн сулрал	10	• Өнчин тархины үйл ажиллагааны алдагдал	3
• Тархины саа, саажилтын хам шинж	8	• Иценги кушенгийн өвчин	1
• Тархи усжих	8	• Congenital adrenal hyperplasia	1
• Епилепси	7	VIII. Арьс ба арьсан доорхи эслэгийн өвчин	3
• Мэдрэл, мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг	6	IX. Гэмтэл хордлого гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	21
• Тархины уйланхай	4	• Дээд мөчдийн гэмтлийн үлдэц	3
• Хүүхдийн тархины саа	4	• Дээд мөчний мултрал, сугалтын үлдэц	2
• Паркинсоны эмгэг	3	• Нугасны гэмтлийн үлдэц	2
• Захын мэдрэлийн үрэвсэл	3	• Доод мөчдийн гэмтлийн үлдэц	2
• Нуруу нугасны ивэрхий	3	• Гавал доторхи гэмтлийн үлдэц	2
• Энцефалопатия	1	• Доод мөчдийн шөрмөсний гэмтэл	2
II.Зүрх судасны	24	• Нүүрний ясны хугарлын үлдэц	1
• Хэрлэгийн гаралтай зүрхний өвчин	6	• Хүзүү ба их биеийн гэмтлийн үлдэц	1
• Тархины судасны өвчин	5	• Түлэгдлийн үлдэц	1
• Вольф паркинсон Уайтын хам шинж	3	• Хиймэл үе суулгах хагалгаа хийлгэх	5
• Гол судасны аневризм	3	X. Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	15
• Венийн өргөсөл	3	• Чонон яр	5
• Гүрээний артерийн аневризм	2	• Бодисын солилцооны шалтгаант артроз	2
• Пароксизмт тахикарди	1	• Нурууны остеохондроз	2
• Артерийн даралт багасалт	1	• Дерматомиозит	2
III.Хоол боловсруулах тогтолцооны	21	• Нурууны мурийлт	1
• Элэгний хатуурал	19	• Эмгэг хугаралгүй ясны сийрэгжилт	1
• Кроны өвчин	1	• Хугархай удаан бороолох	1
• Амны салстын үрэвсэл	1	XI.Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	4
IV. Шээс бэлгийн тогтолцооны	14	• Дуу дамжуулах хэлбэрийн дүлий	4
• Бөөрний архаг дутмагшил	6	XII.Төрөлхийн гажиг ба гаж хөгжил	5
• Давсагны мэдрэл булчингийн үйл ажиллагааны хямрал	3	• Хромосомын гажиг	3
• Бөөрний түүдгэнцрийн архаг үрэвсэл	2	• Уруул тагнайн сэтэрхий	1
• Бөөрний чулуу	2	• Битүүрээгүй артерийн цорго	1
• Шээлүүрийн стриктур	1	XIII. Сэтгэцийн ба зан төрхийн гажиг	2
V.Амьсгалын тогтолцооны	6	• Шизофрени	2
• Уушигны силикоз	2	XIV.Халдварт ба шимэгчит зарим өвчин	5
• Уушигны архаг бөглөрөлт өвчин	2	• Элэгний вируст гепатит	4
• Багтраа	2	• Хялгасан хорхойг өвчин	1
VI.Нүд ба түүний дайрын өвчин	6		
• Харааны мэдрэлийн хатингаршил	2	XV.Онош тодорхойгүй	2
• Төрөлхийн эвэрлэгийн гажиг	2		
• Глауком	1		
• Блефароспазм	1		


Хүснэгтээс харахад:

- Мэдрэлийн тогтолцооны өвчнөөс булчингийн сулрал, тархины саа, саажилтын хам шинж, тархи усжих
- Зүрх судасны өвчнөөс хэрлэгийн гаралтай зүрхний өвчин, тархины судасны өвчин
- Хоол боловсруулах тогтолцооны өвчнөөс элэгний хатуурал
- Шээс бэлгэсийн тогтолцооны өвчнөөс бөөрний архаг дутмагшил гэсэн өвчнүүд илүү нэрлэгдсэн байна.

Мөн дүгнэлт гаргуулаагүй болон дүүргийн эмнэлгээс дүгнэлт гаргуулсан гэж хариулсан зарим иргэд гэдэсний цагаан хорхой, артерийн даралт багасалт, хугархай удаан бороолох гэх мэт өвчнүүдийг ч гадаадад эмчлүүлэх хэрэгцээтэй гэж үзсэн байна. Бид судалгаандаа оношилгоо, эмчилгээ хийлгэхээр эмнэлгийн дүгнэлт гаргуулсан орныг судлахыг зорьсон боловч, цөөнгүй иргэд энэ талаар мэдээлэл хомс, аль улсын ямар эмнэлэгт хийлгэх талаар тодорхой мэдээлэл өгч чадахгүй байв.

Өөрөөр хэлбэл дүгнэлт гаргуулсан гэсэн боловч аль улсад эмчлүүлэх талаар шийдвэр гараагүй, ихэвчлэн Солонгос улсыг нэрлэж байлаа. Иймд дүрслэлээр дүгнэлт гаргуулсан орон гэхээсээ, иргэдийн зорьж очихыг хүссэн гадаад орон гэдгийг харуулахыг зорилоо.

ДҮРСЛЭЛ 6. ИРГЭДИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭХИЙГ ХҮСЧ БАЙГАА ОРОН



Судалгаанд хамрагдсан иргэдийн 61.1% нь Солонгос, 12.5% нь Хятад, 6.1% нь Энэтхэг, 3.7% нь АНУ, 3.0% нь Япон, 2.6% нь Герман, мөн хувиар Тайланд, 2.1% Тайвань, 6.6% нь бусад улс оронг нэрлэсэн байна. Эндээс харахад манай улсын иргэдийн дийлэнх нь БНСУ-д оношилгоо, эмчилгээ хийлгэхийг хүссэн байна.

2.2. Гадаадад оношлуулах, эмчлүүлэх хүсэлтэй иргэдийн санал, хүсэлт

Бид судалгаандаа иргэдийн санал, хүсэлтийг сонсохоор нээлттэй асуулга оруулсан ба мөн иргэд өөрсдийн биеэр ирж, судалгаанд оролцоход нь ярилцлага өрнүүлэн, санал хүсэлтийг сонсон, дүгнэлт хийлээ. Иргэд эмнэлгийн дүгнэлт гаргуулаад явж чадаагүй, мөн өөрийн хүсэлтээр гадаадад оношилгоо, эмчилгээ хийлгэж чадахгүй байгаа шалтгаанаа санхүүгийн хүчин чадал байхгүйтэй холбон тайлбарлаж байна. Мөн монгол эмч нарын мэдлэг ур чадвар хангалтгүй, оношилгоо, эмчилгээг цаг алдаж хийдэг ажлын хариуцлага сул байгаа, мэдээлэл багатай, өнчин эм буюу ховор төрлийн эмийн олдоц хангалтгүй, гадаадад эмчлүүлэхэд улсын эрүүл мэндийн байгууллагуудын зуучлал хангалтгүй байгаа гэсэн байна.

Шигтгээ 1. Судалгаа авч байгаад маш их баярлалаа. Бидний анхны хүү 10 сартай. Цөсний сувгийн төрөлхийн битүүрэл оноштой, ЭХЭМҮТ-д хагалгаанд орсон ч элэг шилжүүлэх шаардлагатай байгаа, зардлаас шалтгаалан явж чадахгүй байгаа. Ийм хүүхэдтэй гэр бүл олон байгаа ч нэгдсэн, бүртгэл, мэдээлэл байхгүй байгаа нь харамсалтай санагддаг. Тиймээс аль болох гадаадад хийлгэж байгаа оношилгоо, эмчилгээний талаар олон сувгаар мэдээлэл өгч байх нь чухал байна, бид элэг шилжүүлэн суулгах эмнэлгийн үнийн саналын талаар багагүй мэдээлэл өгч, туслахад бэлэн байна.

Хүүгийн аавын ярианаас

Шигтгээ 2. Монгол оронд зарагдах зөвшөөрөлтэй эмийн жагсаалтад дархлаа дарангуйлах эм байдаггүй, шинжилгээний хариу нарийн гардаггүй учраас эмчлэх явцад өвчнийг улам хүндрүүлдэг, бусад хоол боловсруулах болон мэдрэлийн эрхтнүүдийг хамтад нь хамгаалах эмчилгээ дутуу хийгддэг, бусад эрхтнүүд өвчиллөө ч хавсарсан онош гаргаж эмчлэх боломжгүй зэрэг нь гадаад явах шалтгаан болдог

Судалгаанд оролцогчийн ярианаас

Судалгаанд цөөнгүй иргэд биеэр ирж хамрагдсан ба тэд гадаадад оношлуулах, эмчлүүлэхэд эрх зүйн тогтолцоо хангалтгүй, гадаадад оношлуулах, эмчлүүлэхэд төрийн албаны зөвлөлийн албан хаагчид илүү эрх мэдэлтэй, сайдын тушаалд байхгүй өвчний шалтгаанаар явж чаддаг, илүү санхүүжилт олж авч чаддаг тухай ярьсан юм.

Мөн гадаадад оношлуулах, эмчлүүлэх гадаад эмчилгээний зуучлалын байгууллагын нэгдсэн тогтолцоо байхгүйгээс ямар ч хамаагүй байгууллагад итгэн, зуучлуулсанаас очсон хойноо эрсдэлд ордог талаар ярьж байлаа. Иргэдийн дийлэнх нь төрийн захиргааны төв байгууллага

бодлогоор эрүүл мэндийн аялал, зуучлалыг нэгдсэн тогтолцоогоор хангах, өндөр өртөгтэй эмчилгээ хийлгэж байгаа иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олбор олгодог тогтолцоонд шилжих талаар Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран ажиллах, эрүүл мэндийн технологи, техникийн хөгжлийг шинэчлэх, эрүүл мэндийн зээлийн лизинг бий болгоход бусад салбартай хамтран ажиллах нь чухал байгааг онцолсон байна.

Шигтгээ 3. Монголд эмчлэх боломж нөхцөлийг хангахын тулд 3-р шатлалын эмнэлгүүдийг тоног төхөөрөмжөөр яаралтай хангаж өгөх хэрэгтэй байна. Тоног төхөөрөмж байхгүйгээс эмч нар гадагшаа явахыг зөвлөж байна. Хэдийгээр эмч нар боломжийн хирээр бэлтгэгдэж байгаа боловч тэдэн өнөөдөр тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь алга байна.

Судалгаанд оролцогчийн ярианаас

Мөн олон иргэд энэхүү судалгаа нь маш чухал бөгөөд, Эрүүл мэндийн сайд, эрүүл мэндийн салбар судалгааны мөрөөр тодорхой арга хэмжээ авна гэдэгт найдан, Монголдоо эмчлүүлдэг болно гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

ДҮГНЭЛТ

Гадаадад эмчлүүлэх шаардлагатай иргэдийн судалгаанд цахимаар 127, утсаар болон биеэр 295, нийт 422 иргэн өөрийн хүсэлтээр хамрагдсан ба эмэгтэйчүүд илүү оролцсон байна. Насны бүлгээр авч үзэхэд 0-15 насны хүүхдүүд олон байгаа нь анхаарал татаж байна.

Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх хувь нь лавлагаа төвүүдээр дүгнэлт гаргуулсан гэсэн ба цөөн хувь нь хувийн эмнэлэг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг нэрлэжээ. Иргэдийн 54.9% нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 107, 2013 оны 313 дугаар тушаалаар Монголд эмчлүүлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон оношилгоо, эмчилгээний чиглэлээр гадаадад эмчлүүлэх хэрэгцээтэй гэсэн бол 190 иргэн бусад шалтгаанаар оношилгоо, эмчилгээ хийлгэх шаардлагатай гэсэн байна.

Гадаад оронд зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний эхний байранд төрөл бүрийн хавдар, зүрхний гажигууд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал орж байгаа бол бусад шалтгааны эхний байранд мэдрэлийн тогтолцоо, зүрх судасны өвчнүүд орж байна. Иргэдийн дийлэнх БНСУ-ыг эмчилгээ хийлгэх сонирхолтой байгаа ба санхүүгийн боломжоос шалтгаалан явж чадахгүй байна.

Иргэд гадаадад оношлуулах, эмчлүүлэх бодлого, эрх зүйн орчныг сайжруулах, эрүүл мэндийн аялал, зуучлал, эрүүл мэндийн лизинг, технологийг хөгжүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, хариуцлагыг сайжруулах замаар Монголдоо эмчилдэг болох хэрэгцээ шаардлага байгааг онцолж байна.

ЗӨВЛӨМЖ

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлогын 1.3.3-т заасан” ...Одоо хийж чадахгүй байгаа өндөр нарийвчлал, технологи шаардсан эмнэлгийн тусламжийг эх орондоо үзүүлж, гадаадын ижил төстэй эмнэлгүүдтэй өрсөлдөх түвшинд хүргэнэ” гэсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг өргөн далайцтай зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах
- Бодлогын түвшинд гадаадад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний хамгийн өндөр тохиолдож байгаа чиглэлээр (мэс засал) өндөр хөгжилтэй орнуудаас эмч нарын баг урих компани ажлыг лавлагаа төвүүд, өндөр технологи бүхий хувийн эмнэлгүүдтэй (Гранд-Мед, Сонгодой, Интермед, Гурван-Гал гэх мэт) хамтран зохион байгуулах замаар ажиллан, монголын эмч нар, эмнэлгийг чадавхижуулах
- Өндөр технологи, мэргэшсэн баг, чадавхи бүхий хувийн эмнэлгийг бодлогоор хөгжүүлэн, гадаадад эмчлүүлэх заалттай тусламж үйлчилгээ үзүүлж буй тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг тогтолцоонд шилжих
- Иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлж байсан иргэдийн гадаадад эмчилгээ хийлгэх зардлын тодорхой хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгодог эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Лавлагаа төвүүдээс өндөр мэргэшлийн мэс засалчдын багийг бүрдүүлэх
- Гадаадад оношилгоо, эмчилгээ хийлгэж байгаа чиглэлээр тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, эмч мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах, ур чадварыг нь дээшлүүлж, эх орондоо эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх
- Гадаадад эмчилгээ хийлгэхээр дүгнэлт гаргуулсан иргэдийг тухайн улс орны эмнэлгүүдэд зуучлах, мэдээлэл авахад дэмжлэг үзүүлэх нэгдсэн сайттай болох
- Гадаадад эмчилгээ хийлгэх эрүүл мэндийн бага хүүтэй лизингийн зээл олгох, эргэн төлөх боломжийг судалж шийдвэрлэх